



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/М

Улаанбаатар хот

Нохой, муур устгал, бүртгэлжүүлэх ажлын хуваарь,
санхүүжилтийн задаргаа батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургаа дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6/11 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Төсөв батлах тухай” 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2019 оны 01 дүгээр тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.5, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн хурлын 2019 оны 21 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын 2020 оны төлөвлөгдсөн зардлаас санхүүжих нохой муур устгалын ажлын тоо хэмжээ, шаардагдах зардлын хэмжээг 1 дүгээр, Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын айл өрхийн нохой, муурыг бүртгэлжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, вакцин, туулганд хамруулах, үржлийг хязгаарлах ажлын төсвийг 2 дугаар, эзэнгүй нохой, муурны устгалын ажлыг хариуцан ажиллах байгууллагуудын нутаг дэвсгэрийн хуваарийг 3 дугаар, сар бүрийн устгал хийх хуваарийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Эзэнгүй нохой, муур устгал, гэр хорооллын айл өрхийн нохой бүртгэлжүүлэх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасугай.


2.1 Нохой, муур устгалын ажлыг 2019 онд чанартай гүйцэтгэж, гэрээний үүргийн биелэлт нь бүрэн хангалттай дүгнэгдсэн тушаалын 3 дугаар хавсралтад заасан нохой, муур устгалын үйлчилгээний мэргэжлийн байгууллагуудтай нийслэлийн 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд гэрээ байгуулах, Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын айл өрхийн нохой, муурыг бүртгэлжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, вакцин, туулганд хамруулах, үржлийг хязгаарлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус зохион байгуулж ажиллахыг Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын хэлтэс /С.Аригуун/-т,

2.2 Нохой бүртгэлжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн нохойнд урьдчилан сэргийлэх үзлэг хийх, вакцин, туулганд хамруулах, үржлийг хязгаарлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан мэргэжлийн

байгууллагыг мэргэжил арга зүйгээр удирдаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар /А.Нарантуяа/-т тус тус.


3. Эзэнгүй нохой, муур устгал, гэр хорооллын айл өрхийн нохой бүртгэлжүүлэх ажилд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албыг төлөөлөн холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгч, өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг Бид туслая төрийн бус байгууллага /Ч.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

4. Эзэнгүй нохой, муур устгалын ажилд шаардагдах 1,200,000,000 /Нэг тэрбум хоёр зуун сая/ төгрөгийг гүйцэтгэгч байгууллагуудын сар бүрийн гүйцэтгэлээр тооцож санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны сарын өдрийн
А/М тушаалын хавсралт



НОХОЙ, МУУР УСТГАЛЫН ТОО ХЭМЖЭЭ,
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Төсвийн хуваарилалт	Тоо хэмжээ /ш/	Нэгж зардал /төг/	Төлбөр /төгрөг/
1	Сонгинохайрхан дүүрэг	20,000	12,000	240,000,000
2	Хан Уул дүүрэг	15,000	12,000	180,000,000
3	Баянгол дүүрэг	15,500	12,000	186,000,000
4	Чингэлтэй дүүрэг	10,000	12,000	120,000,000
5	Сүхбаатар дүүрэг	15,000	12,000	180,000,000
6	Баянзүрх дүүрэг	20,000	12,000	240,000,000
7	Налайх дүүрэг	2,000	12,000	24,000,000
8	Багануур дүүрэг	1,500	12,000	18,000,000
9	Багахангай дүүрэг	1,000	12,000	12,000,000
	Нийт	100,000	12,000	1,200,000,000


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны сарын өдрийн
тушаалын хавсралт



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ГЭР ХОРООЛЛЫН НОХОЙ,
МУУРЫГ БҮРТГЭЛЖҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ХИЙХ,
ВАКЦИН ТУУЛГАНД ХАМРУУЛАХ, ҮРЖЛИЙГ ХЯЗГААРЛАХ АЖЛЫН ТӨСӨВ

Д/д	Төсвийн хуваарилалт	Тоо хэмжээ /ш/	Нэгж зардал /төг/	Төлбөр /төгрөг/
1	Нохойны паспорт хэвлүүлэх ажил	20,000	1,000	20,000,000
2	Нохойны пайз хийлгэх ажил	20,000	1,700	34,000,000
3	Нохойны хүзүүвч хийлгэх ажил	20,000	5,300	106,000,000
4	Нохой, муурыг бүртгэлжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг хийх, вакцин туулганд хамруулах, үржлийг хязгаарлах ажил	20,000	13,330	266,600,000
5	Эр нохойны үржил хязгаарлах ажил	500	22,500	11,250,000
6	Эм нохойны өндгөвч авах мэс ажилбар	500	95,000	47,500,000
	Нийт дүн			485,350,000


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 07-р сарын 14 өдрийн
А.М.Тушаалын 03-р хавсралт



НОХОЙ, МУУР УСТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНД
ХАРИУЦАН АЖИЛЛАХ НУТАГ ДЭВСГЭРИЙН
ДЭВСГЭРИЙН ХУВААРЬ

Д/д	Байгууллага	Хариуцах нутаг дэвсгэр
1	ӨЛТЭ ХХК	Сонгинохайрхан дүүрэг Хан-Уул дүүрэг, Налайх дүүрэг
2	Их булаг атүк ХХК	Чингэлтэй дүүрэг Баянгол дүүрэг
3	Базалт нэгдэл ХХК	Баянзүрх дүүрэг Сүхбаатар дүүрэг
4	Багануур дүүргийн тохижилт ОНӨААТҮГ	Багануур дүүрэг
5	Багахангай дүүргийн Хот тохижилтын алба ОНӨААТҮГ	Багахангай дүүрэг

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2020 оны 01.14 сарын 14 өдрийн
 А.Н. тушаалын 045/р хавсралт



САР БҮРИЙН УСТГАЛ ХИЙХ ХУВААРЬ /2020 ОН/

Сар	ӨЛТЭ ХХК	Их булаг атүк ХХК	Базалт нэгдэл ХХК	Багануур дүүргийн тохижилт ОНӨААТҮГ	Багахангай дүүргийн Хот тохижилтын алба ОНӨААТҮГ
	ХУД, СХД, НД	БГД, ЧД	СБД, БЗД	БНД	БХД
1	3000	2500	3000		
2	3000	2000	3000	500	
3	3500	2000	3000		
4	3000	2000	3000		500
5	3500	2000	3000		
6	3000	2000	3000	500	
7	2500	2000	2500		
8	3000	2000	3000		
9	3500	2000	3000		
10	3000	2500	3000		
11	3500	2500	3000		500
12	2500	2000	2500	500	
	37000	25500	35000	1500	1000
Нийт	100000				